

# САНХҮҮГИЙН БУС БИЗНЕС, МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН 2022 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТОЙМ

---


ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ, ҮНЭТ  
ЭДЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 441 иргэн, 43 хуулийн этгээдэд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон байна.

Хөдөө, орон нутаг  
19.7%




Улаанбаатар  
80.3%

Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нийт тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 80.3 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 19.7 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд


Тайлант улиралд нийт 43 хуулийн этгээдэд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон байна.



ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН  
ХӨРӨНГӨ


Тайлант улиралд тусгай зөвшөөрөлтэй 43 хуулийн этгээдийн 75 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 9.3 тэрбум төгрөг байна.

## УЛААНБААТАР ХОТОД



## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд


Тайлант улиралд нийт 441 иргэдэд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон байна. Үүнээс, үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 244, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 130, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 67 иргэн бүртгэлтэй байна. Дараах зурагт хувиар илэрхийлэн үзүүлэв.




### УЛААНБААТАР ХОТОД

### ХӨДӨӨ, ОРОН НУТАГТ


## Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд



## Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



## Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч



### ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛЫН ДҮН:

Тайлант хугацаанд 267.7 кг алтыг 39.3 тэрбум төгрөгөөр худалдан авч, 316.7 кг алтыг 50.8 тэрбум төгрөгөөр борлуулсан байна. Энэ нь 2021 оны 1-р улиралтай харьцуулбал худалдан авсан алтны хэмжээ 62 хувиар, худалдсан алтны хэмжээ 50 хувиар буурсан байна.

#### ХУДАЛДСАН

АЛТ

МӨНГӨ

50.8 ТЭРБУМ  
ТӨГРӨГ

69.2 САЯ  
ТӨГРӨГ



#### ХУДАЛДАН АВСАН

АЛТ

МӨНГӨ

39.3 ТЭРБУМ  
ТӨГРӨГ

28.2 САЯ  
ТӨГРӨГ



### ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН:



Үнэт эдлэлийн борлуулалтын И-Баримтын мэдээгээр 2022 оны 1 дүгээр улиралд давхардсан тоогоор 98 үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээд нь 2,516 харилцагчид 4,545 бүтээгдэхүүнийг 3.3 тэрбум төгрөгөөр худалдан борлуулсан байна.

## ХАМТЫН АЖИЛЛАГАА

Соёлын яам, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нэгдсэн холбоотой 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр хамтарсан уулзалтыг зохион байгуулсан ба энэхүү уулзалтаар төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, соёлын үйл ажиллагаанд салбарын оролцогчдын тэгш оролцоог хангах, соёлын өвийг хамгаалах чиглэлд хамтран ажиллахаар санал солилцсон.

01

Монголбанк, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн нэгдсэн холбоотой 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр уулзалт зохион байгуулсан бөгөөд тус уулзалтаар үнэт металлын арилжаа эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.

02

Монгол банк, Татварын ерөнхий газартай 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр хамтарсан уулзалтыг зохион байгуулсан ба тус уулзалтаар үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн өнөөгийн байдал, хууль, эрх зүйн орчны талаар хэлэлцэж, цаашид салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлд идэвхтэй оролцож, хамтран ажиллахаар болов.

03


Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн нэгдсэн уулзалт, “Mongolian jewellery & metal expo-2022” үзэсгэлэнг 2022 оны 4 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд “Мишээл экспо” олон улсын худалдааны танхимд зохион байгуулав.

04

# ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тайлант улиралд нийт 262 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос олгосон байна.



ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ


Тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын 390 хувьцаа эзэмшигчдийн нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5.5 тэрбум төгрөг байна

## БРОКЕР, АГЕНТЫН МЭДЭЭЛЭЛ

Нэг үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага дунджаар 1 брокер, 4 агенттайгаар ажиллаж байна. Хамгийн олон агенттай үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын агентын тоо 93 байна.


### БРОКЕР

282




### АГЕНТ

1,370



## УЛААНБААТАР ХОТОД


НИЙТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮХЭХЗ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН 30.6 ХУВЬ НЬ СҮХБААТАР, 23.6 ХУВЬ НЬ ХАН-УУЛ, 12.6 ХУВЬ НЬ ЧИНГЭЛТЭЙ, 17.6 ХУВЬ НЬ БАЯНЗҮРХ, 12.6 ХУВЬ НЬ БАЯНГОЛ, 1.9 ХУВЬ НЬ СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ТУС ТУС ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БАЙГАА БОЛ ХӨДӨӨ, ОРОН НУТАГТ 3 ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА БУЮУ 1.1 ХУВЬ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БАЙНА.




## ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Давхардсан тоогоор 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар ҮХЭХЗ-ын байгууллага нийт 1,621 хэлцлээр, 296,3 мянган м.кв талбай, 275.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан худалдан, шилжүүлжээ.

**Шимтгэлийн хувь / Борлуулсан хэлцлийн тоогоор/**




**Талбайн хэмжээ /Борлуулсан хэлцлийн тоогоор/**




## ТҮРЭЭСЛЭХ, ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ, ХӨЛСЛҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийт 659 хэлцлээр 61.3 мянган м.кв талбай, 12.5 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.

**Шимтгэлийн хувь / Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/**



**Талбайн хэмжээ / Түрээсэлсэн хэлцлийн тоогоор/**



## ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дээвэр нэгдсэн холбоо” ГҮТББ-тай 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр уулзалт зохион байгуулж, цаашид холбогдох хуулийн төсөлд хамтран ажиллахаар болов.

01

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын тухай хууль болон хуулийн үзэл баримтлалыг танилцуулах хэлэлцүүлгийг зөвлөхтэй хамтран 2 удаа зохион байгуулсан.

02

Барилга хот байгуулалтын яамны технологийн хэлтэс, Геодези зураг зүйн газрын хот байгуулалын кадастрын хэлтэс, Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдөр уулзалт зохион байгуулж, орон сууцны тухай хуульд заасан орон сууцны мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, сүлжээ байгуулахад хамтран ажиллах хүрээнд санал солилцож, “Санамж бичиг” байгуулахаар болсон.

03

Барилга хот байгуулалтын яам, Үл хөдлөхийн салбарын үйл ажиллагааг зохицуулсан хуулийн төслийн зөвлөх нарын хамтарсан уулзалтыг 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан ба тус уулзалтаар орон сууцны мэдээллийн сангийн талаар санал солилцсон.

04